

ТӨРӨӨС ХИЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО, ТҮҮНИЙ АГУУЛГА

Б.Цэдэндамба

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 8022 дугаар дамжааны суралцагч, дэд хурандаа

Товч агуулга: Төрөөс хилийн талаар баримтлах бодлого нь Монгол Улсын Үндсэн хуулийн тулгуур хууль, эрх зүйн үзэл баримтлал болох үндэсний аюулгүй байдлын бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйлст чухал байр эзэлж байна. Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах, механизмыг боловсронгуй болгох, Хил хамгаалах албаны бүтэц, үйл ажиллагаа, Хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх чиглэлийн талаар дурдахыг хичээв.

Abstract: The state's border policy occupies an important place in the national security policy and its implementation, which is the basic law and legal concept of the Constitution of Mongolia. He tried to mention the inviolability of the state border, the security of the border area, the improvement of the mechanism, the structure and operation of the Border Guard Service, and the direction of the implementation of the border policy.

Түлхүүр үг: Төрөөс хилийн талаар баримтлах бодлого, хилийн аюулгүй байдал.

Keywords: The government's border policy, border security.

ОРШИЛ

Төрийн хилийн бодлого нь Монгол Улсын цэргийн бодлого /номлол/-д чухал байр эзэлж улс орныг батлан хамгаалах тэргүүн шугам болох улсын хилийг манаж, хамгаалах чухал зорилтуудыг хэрэгжүүлж байна. Монгол Улсын хилчид улсын хил, хил орчмын, бүс нутгийн шинжтэй, орон нутгийн хэлбэртэй хамгаалалтыг гүйцэтгэхийн зэрэгцээ хил манах үндсэн хүч нь хилчид байдаг онцлогтой бөгөөд улсын хилийг өөрчлөлтгүй, зөрчилгүй байлгах эрх үүргийг Хил хамгаалах байгууллага хүлээдэг.¹

Хил хамгаалах байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхэд мөрдлөг болгох хууль эрх зүйн баримт бичгүүдэд хилийн аюулгүй байдлын талаар дараах байдлаар тусгажээ.

• **Монгол Улсын үндсэн хуульд:**

- “Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал халдашгүй дархан байна”²

• **Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд:**

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг

¹ Арвай Ш., “Монгол Улсын төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлого, стратегийн онцлог”, УБ., 2015. Т. 15

² Монгол Улсын Үнсэн хууль., УБ., 1992.

хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ.

- Язгуур ашиг сонирхол: Үндэсний аюулгүй байдлыг хангах зорилт нь улс үндэсний язгуур ашиг сонирхол буюу хамгийн чухал үнэт зүйлсийг хамгаалахад чиглэгддэг. Үүнд: Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдал;

- *Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам:*

Оршин тогтнохуйн аюулгүй байдал

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах нь оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс мөн хэмээн хил хязгаар, нутаг дэвсгэрийн халдашгүй, бүрэн бүтэн байдал юм;¹

• **Монгол Улсын Хилийн тухай хуульд: - 5 дугаар зүйл “Монгол Улсын хилийн аюулгүй байдал:**

- Монгол Улсын хилийн аюулгүй байдал нь /цаашид “хилийн аюулгүй байдал” гэх/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг мөн.

- Хилийн аюулгүй байдал гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байхыг хэлнэ.

- Хилийн аюулгүй байдал нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт

үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн эрх бүхий байгууллагуудаас нэгдмэл бодлого, харилцан уялдаатай явуулах улс төр, эрх зүй, дипломат, эдийн засаг, байгаль орчин, тагнуул, улсын хил хамгаалалтын цогц үйл ажиллагаагаар хангагдана.

- Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, байгууллага, иргэний үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах асуудлыг Засгийн газар хариуцна. ² хэмээн тусгасан байдаг.

Төрийн хилийн бодлого нь Монгол Улсын Их Хурлаар 2002 онд батлагдаж, одоо хүртэл мөрдөгдөж байна. Төрийн хилийн бодлого нь улсын хилийн баталгаажилт, хамгаалалтын тулгамдсан асуудлуудыг шинжилгээ судалгаагаар гаргаж тэдгээрийг зүй зохистой шийдвэрлэх шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах, эрх зүйн баталгаатай болгох, хэрэгжилтийг аргачлалаар хангах үйл ажиллагаанд чиглэдэг.³

Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого /цаашид "Хилийн талаар баримтлах бодлого" гэх/ нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын салшгүй хэсэг мөн.

2. Хилийн талаар баримтлах бодлого нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд үндэслэсэн улсын хил, хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй

¹ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал., УБ., 2010.

² Монгол Улсын Хилийн тухай хууль., УБ., 2016.

³ Арвай Ш., “Монгол Улсын төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлого, стратегийн онцлог”, УБ., 2015. Т. 15

байдлын талаарх Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрийн үндэс болсон залгамж чанартай тулгуур баримт бичиг мөн.

3.Хилийн талаар баримтлах бодлого нь байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдэнэ.

4.Хилийн талаар баримтлах бодлого нь бусад улсын тусгаар тогтнолыг хүндэтгэх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг дээдлэх, хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжлийг хангах, улсын хил дээр хүч хэрэглэхээс аль болох зайлсхийх, аливаа асуудлыг энхийн аргаар шийдвэрлэхийг эрмэлзэх зарчимд тулгуурлана.

5.Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг шинжлэх ухаан, техник, технологийн ололт, мэргэшсэн байгууллагын үйл ажиллагаанд тулгуурлан цогц байдлаар зохион байгуулна.

6.Улсын хил нь хил залгаа улстай байгуулсан олон улсын гэрээгээр тодорхойлогдох бөгөөд Монгол Улсын хуулиар баталгаажсан байна.

7.Улсын хилийн халдашгүй дархан байдал нь хилийн шугам хууль бусаар өөрчлөгдөөгүй, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр зөрчигдөхгүй байх явдлаар хангагдана.

8.Хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхол тухайн нутаг дэвсгэрт хангагдсан байдлаар тодорхойлогдоно.

9.Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах асуудлыг Засгийн газар хариуцна.

Хилийн талаар баримтлах бодлогын үндсэн чиглэл

1.Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах талаар:

1/ улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах талаар олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах, нэгдэн орох, тэдгээрийг хүндэтгэн сахиx, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгож байх;

2/ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан хилийн бүс, зурвасын эзэмшлийг сайжруулж, хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжлийн талаар нийгэм, эдийн засгийн цогцолбор арга хэмжээ авах;

3/ улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр дэх газар нутгийн уламжлалт монгол нэр, түүх, соёлын дурсгалт зүйлсийг хэвээр хадгалах;

4/ хил орчмын нутаг дэвсгэрийн стратегийн ач холбогдол бүхий байгалийн нөөц, баялгийг төрийн хяналтад байлгах;

5/ хилийн асуудлаар хил залгаа улсын холбогдох байгууллагуудтай тогтоосон харилцааг хөгжүүлэх;

6/ улсын хил дээр зэвсэгт халдлага, түрэмгийлэл үүсэхээс урьдчилан сэргийлж, хилийн асуудлаар үүссэн зөрчил, будилааныг энхийн аргаар шийдвэрлэхийг эрхэмлэх;

7/ хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх, байгалийн гамшиг, хүн малын гоц халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх, хил орчмын нутаг дэвсгэрт хүмүүнлэгийн болон экологийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хил залгаа болон бусад орнуудтай хамтран ажиллах;

8/ улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, цаг алдалгүй илрүүлэх, таслан зогсоох, шийдвэрлэх арга хэмжээг цогц байдлаар хэрэгжүүлэх;

9/ хил орчмын нутаг дэвсгэр, хилийн боомт газарт эмх замбараагүй байдал үүсэхээс сэргийлэх;

10/ эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааны зарчимд тулгуурлан, дэд бүтэц, барилга байгууламж бүхий хилийн хяналт шалгалт явуулах нөхцөлийг хангасан хилийн боомтуудыг ажиллуулах;

11/ улсын хил хамгаалах байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлэх;

12/ иргэдийн эх оронч үзэл, улсын хил, хилийн дэглэм, журмыг хүндэтгэн сахих хүмүүжлийг төлөвшүүлэх.

2. Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах механизмыг боловсронгуй болгох талаар:

1/ улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны зохицуулалт, уялдаа холбоог сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

2/ хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлж, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг хил хамгаалалтын бодлого, үйл ажиллагааны үндэс болгох;

3/ улсын хилийн бүс, зурвас, боомт газарт орчин үеийн шаардлагад нийцсэн холбоо, хяналт, дохиолол, зам, тээвэр, инженерийн байгууламж бүхий хил хамгаалалтын дэд бүтцийг хөгжүүлэх;

4/ агаарын хилийн хяналтыг боловсронгуй болгоход чиглэсэн дэвшилтэт техник, хэрэгслийг нэвтрүүлэх;

5/ зорчигч, тээврийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх үйл ажиллагааг шуурхай болгож, хилийн боомт газарт ажиллах хяналтын албадын үйл ажиллагааг нь уялдуулан, нэгдсэн зохицуулалтад оруулах;

6/ хил орчмын оршин суугчдаас хил хамгаалалтад оролцох явдлыг хөхүүлэн дэмжих, урамшуулах, улсын хилийн бүс, зурваст тогтвортой суурьших нөхцөлийг бүрдүүлэх;

7/ хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх байгууллагуудыг эх оронч, мэдлэг, чадвартай боловсон хүчнээр хангах, тэдгээрийн нийгмийн хангамж, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулж, тэдний ар гэрийн нийгмийн баталгааг бодитойгоор дэмжих;

8/ төрөөс аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн Монгол Улсын үндэсний эрх ашигт үл харшлах хилийн харилцааг чөлөөтэй байлгах.

3. Хил хамгаалах албаны бүтэц, үйл ажиллагааны талаар:

1/ хил хамгаалах албыг ямар ч нөхцөлд улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах чадвар

бүхий нэгдмэл бүтэц, зохион байгуулалттай байлгах;

2/ хил хамгаалах албаны үйл ажиллагаанд улс төр, дипломат, тагнуул, инженер-техник, хяналтын

Хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх чиглэл

1.Хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж удирдах, түүнийг хэрэгжүүлэгч байгууллагын санхүүжилт, материал техникийн хангамжийн норм хэмжээг тогтоох, хуулиар олгогдсон эрх хэмжээний дагуу хилийн асуудлаар олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах зэрэг асуудлыг Засгийн газар хариуцаж хэрэгжүүлэх.

2.Байгууллага, иргэд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хил орчмын нутаг дэвсгэрт хангах талаар хүлэсэн үүргээ Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн дагуу биелүүлэх.

ДҮГНЭЛТ

Дэлхийн Улс орнууд улсын тусгаар тогтнол, ард иргэдийнхээ эрх ашгийг нэн тэргүүнд тавих нь зүй ёсны асуудал бөгөөд гагцхүү, энэ эрх ашгийг яаж, ямар байдлаар хамгаалах нь төрийн бодлогоор тодорхойлогдох юм.

Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах нь нэн тэргүүний зорилт тул дээр өгүүлсэнчлэн язгуур эрх ашгаа хангах, хамгаалах явдал хэмээн ойлгож болно.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлого нь:

- *Нэгдүгээр зүйлд: - Нийтлэг үндэслэл - 9 заалт*

Агуулга: - Иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдэх, аливаа асуудлыг энхийн аргаар шийдвэрлэхийг эрмэлзэх зарчимд

болон дэглэм сахиулах зэрэг аргыг оновчтой ашиглах;

3/ хил хамгаалах албыг зохион байгуулж, удирдах байгууллага нь мэргэжлийн байх.

3.Хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хүн, хүч, хөрөнгийн тооцоог гаргаж, жил бүрийн төвлөрсөн болон орон нутгийн төсөв бусад эх үүсвэрээс санхүүжүүлж байх.

4.Хилийн талаар баримтлах бодлогод олон улсын харилцааны хөгжил, дэлхий д ахины болон бүс нутаг, хил залгаа улс дахь цэрэг-улс төрийн байдал, улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үүсэж буй болсон бодит нөхцөл байдалтай уялдуулан Улсын Их Хурал тодотгол хийх.

тулгуурлах, мэргэшсэн байгууллагын үйл ажиллагаанд тулгуурлан цогц байдлаар зохион байгуулах, Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр зөрчигдөхгүй байх явдлаар хангагдах, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах асуудлыг Засгийн газар хариуцахаар талаар тусгасан байна.

- *Хоёрдугаар зүйлд: - Хилийн талаар баримтлах бодлогын үндсэн чиглэл*

1. *Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах талаар: - 12 заалт.*

Агуулга: - Хууль тогтоомжийг боловсронгуй болгож, бүсчилсэн

хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан нийгэм, эдийн засгийн цогцолбор арга хэмжээг авах, газар нутгийн уламжлалт монгол нэр, түүх, соёлын дурсгалт зүйлсийг хэвээр хадгалах, стратегийн ач холбогдол бүхий байгалийн нөөц, баялгийг төрийн хяналтад байлгах, хил залгаа улсын холбогдох байгууллагуудтай тогтоосон харилцааг хөгжүүлэх, хилийн асуудлаар үүссэн зөрчил, будилааныг энхийн аргаар шийдвэрлэхийг эрхэмлэх, хил орчмын нутаг дэвсгэрт хүмүүнлэгийн болон экологийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хил залгаа болон бусад орнуудтай хамтран ажиллах, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, хил хяналтын шалгалт явуулах нөхцөлийг хангасан хилийн боомтуудыг ажиллуулах, алба хаагчдыг мэргэшүүлэх, иргэдийн эх оронч үзэл, улсын хил, хилийн дэглэм, журмыг хүндэтгэн сахих хүмүүжлийг төлөвшүүлэх талаар тодорхой дурдсан байна;

2. *Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах механизмыг боловсронгуй болгох талаар: - 8 заалт.*

Агуулга: - Эрх зүйн орчныг боловсронгуй болгох, судалгааны ажлын үр дүнг хил хамгаалалтын бодлого, үйл ажиллагаанд уялдуулах, хил хамгаалалтын дэд бүтцийг хөгжүүлэх, дэвшилтэт техник, хэрэгслийг нэвтрүүлэх, хилийн боомт-хяналтын албадын үйл ажиллааг нэгдсэн зохицуулалтад оруулах, хилийн бүс, зурваст тогтвортой

суурьших нөхцөлийг бүрдүүлэх; чадвартай боловсон хүчнээр хангах, тэдгээрийн нийгмийн хангамж, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулж, тэдний ар гэрийн нийгмийн баталгааг бодитойгоор дэмжих, төрөөс аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн Монгол Улсын үндэсний эрх ашигт үл харшлах хилийн харилцааг чөлөөтэй байлгах талаар тусгасан;

3. *Хил хамгаалах албаны бүтэц, үйл ажиллагааны талаар: - 3 заалт.*

Агуулга: - Хил хамгаалах албыг ямар ч нөхцөлд аюулгүй байдлыг хангах чадвар бүхий нэгдмэл бүтэц, зохион байгуулалттай байлгаж, дэглэм сахиулах, мэргэжлийн байх чиглэлээр.

• *Гуравдугаар зүйлд: - Хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх чиглэлийн талаар - 4 заалт.*

Агуулга: - Хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж удирдах, хэрэгжүүлэгч байгууллагын санхүүжилт, материал техникийн хангамжийн норм хэмжээг тогтоох, хуулиар олгогдсон эрх хэмжээний дагуу хилийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах зэрэг асуудлыг Засгийн газар хариуцаж хэрэгжүүлэх, шаардагдах хүн, хүч, хөрөнгийн тооцоог гаргаж, жил бүрийн төвлөрсөн болон орон нутгийн төсөв бусад эх үүсвэрээс санхүүжүүлж байх, хил орчмын нутаг дэвсгэрт үүсэж буй бодит нөхцөл байдалтай уялдуулан Улсын Их Хурал тодотгол хийх зэрэг асуудлуудыг тус тус тодорхойлж тусгасан байна.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хуульчилснаар

Улсын хилийн аюулгүй байдлыг хангах, хил хамгаалалтын стратегийн

түвшин тогтвортой байх үндэс юм гэж дүгнэв.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Төрөөс Хилийн талаар баримтлах бодлого”, УБ., 2002 он.

2. Монгол Улсын “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, УБ, 2010 он.

3. Монгол Улсын Хилийн тухай хууль., УБ., 2016 он.

4. Ш.Арвай., “Монгол Улсын Төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлого, стратегийн онцлог., УБ., 2015 он.

5. “Батлан хамгаалах стратеги”-онол арга зүй, шинжилгээний бүтээл., УБ., 2017